

Гэм ба үхлийг бүрэн шийдвэрлэсэн шийдэл

Энэ дэлхий дээр төрсөн хүн бүр зайлшгүй үхэж оршин байхаа болино хэмээн Библи заадаг. Үхэхэд хүргэх шалтгаан бол өвөг эцэг Адамаас өвлөж авсан “уламжлалт үхэл” юм (өмнөх хэдэн нийтлэлийг үзнэ үү!). Энэ үндсэн асуудлыг, мөн үхлээс үүдэх гэм нүглийг хүн төрөлхтөн дийлэхийн ямар ч аргагүй. Зөвхөн Бүтээгч Эзэн энэ асуудлыг шийдэж чадна. Сайхан мэдээ нь Тэр үнэхээр Есүс Христийн загалмайгаар аль хэдийнэ шийдсэн! Гэм ба үхлийг бүрмөсөн шийдвэрлэж чаддаг цорын ганц Нэгэн яагаад Есүс Христ гэдгийг бид энэ нийтлэлд авч үзнэ. Ертөнцийн Эзэний төлөвлөгөөнд гэм ба үхэл хэрхэн үйлчлэх учиртайг мөн авч үзэх болно.

Есүс Христийн тухай сайн мэдээний цөмийг Паул дараах үгээр базаж хэлсэн билээ: “Христ бидний нүглийн төлөө үхсэн бөгөөд оршуулагдан, Бичвэрийн дагуу гурав дахь өдөртөө амилуулагдсан...”

(1 Коринт 15:1-4).

Улмаар: “Бурхан дэлхийг Христ дотор Өөртэйгөө эвлэрүүлж, хүмүүсийн гэм бурууг үл харгалзсан”
(2 Коринт 5:19).



Олон итгэгчийн ойлгосноор Есүс гэмийнх нь шийтгэлийг өмнөөс нь хүлээх гэж нас барсан. Иймд



“Христ бидний нүглийн ТӨЛӨӨ үхсэн” (АБ2004; 1 Коринт 15:3) гэснийг АБ2019-ын орчуулганд “Христ бидний нүглийн УЛМААС үхсэн” гээд өөрчилсөн бололтой. Гэтэл Түүний үхэл бол шийтгэлээс хамаагүй илүү их утга учиртай бөгөөд Адамын алдаа зөрчилтэй шууд холбоотой.

Хоёр үндсэн чухал хүн: Адам ба Христ

Ертөнцийн Эзэний төлөвлөгөөнд үндсэн ач холбогдолтой хоёрхон хүн бий. Эхнийх нь бид бүхний өвөг эцэг Адам. Та төрөхөөсөө өмнө нэг ёсондоо аав ээжийнхээ “дотор” байсан шиг, бүх хүн төрөлхтөн анх Адамын дотор “агуулагдсан” байв. Адам гэм ба үхлийг хамаг үр удамдаа дамжуулснаас хойш хүн төрөлхтөн мөхөх тавилантай болсон. Адамаас гаралтай, амь муутай, мөхмөл хүн төрөлхтөнийг Бичвэрүүд “хуучин хүн төрөлхтөн” гэдэг.



Адам анхны хүн байхад үхэгсдээс амилсан Есүс “хоёрдахь хүн”-д тооцогддог (1 Коринт 15:47). Есүс бол нэг ёсондоо “Адам 2.0” буюу хүн төрөлхтөний шинэ загвар юм. “Хуучны загварын” Адам хуучин хүн төрөлхтөнийг эхлүүлж, тэргүүн нь болсон шиг Есүс “шинэ хүн төрөлхтөн”-ийг үүсгэн тэргүүлнэ. Тэр шинэ хүн төрөлхтөн үхэшгүй амьтай, гэм зэмгүй бөгөөд Адамын дахин амилах бүх үр удмаар нь бүрдэх учиртай.



Энэ төлөвлөгөөгөө биелүүлэхээр Ертөнцийн Эзэн “нүглийг шийдэхийн тулд Өөрийн Хүүг нүгэлт махбодтой адил байдалд илгээн, махбод дотор нүглийг яллажээ” (Ром 8:3).

Ажиглаваас, Есүс “нүгэлт махбодтой” байгаагүй, “махбодтой адил байдалтай” ч байгаагүй, харин “нүгэлт махбодтой адил байдал”-тай байсан. Есүс бусад хүнийх шиг жинхэнэ бие махбодтой байсан ч, биед нь гэм нүгэл оршин байгаагүй гэсэн үг (нүгэл махбодод орших тал дээр Ром 7:17-18-с үзнэ үү).



Есүс ээжийн талаасаа Адамын үр удам болж төрсөн ч гэсэн, Аав нь Ертөнцийн Эзэн билээ. Өөрийн Эцгээсээ Есүс энэ дэлхий дээр байхдаа ч “Өөртөө амь байлгах” эрх авсан (Иохан 5:26). Тийм учраас Адамын шийтгэл Түүнд хамаарахгүй. “Удамшлийн үхэл”

Түүнд нэгэнт байгаагүй тул үхлийн хатгуур болох гэм ч гэсэн Түүнд нөлөөлсөнгүй. Иймд Есүс хэзээ ч гэм нүгэл хийж байгаагүй (Еврей 4:15).

Улмаар, Адамын үр удам болж төрөхөөсөө хол өмнө Есүс “бүх бүтээлийн дээрх Ууган нь” болсон. Ертөнцийн Эзэний Ууган Хүү болох “Түүн дотор тэнгэр ба газар дахь бүх юмс... бүтээгдсэн” (Колоссай 1:15-16). Хүн төрөлхлтөн “Адамын дотор” байсан шиг хамаг ертөнц (Адам ч гэсэн) бүтээгдэхээсээ өмнө Ертөнцийн Эзэний Хүүгийн



“дотор” байсан гэсэн үг. Бид бүхнийг Адамтай холбодог ураг төрлийн холбоо байдаг шиг, хүн төрөлхтөнийг Есүстэй холбодог бас тодорхой амийн холбоос бий. Тийм ч учраас Есүс хамаг хүн төрөлхтөнийг төлөөлөх эрхтэй.

Энэ бүх шалтгаанаас болж Есүс Христ гэм нүгэл ба үхлийн асуудлыг бүрмөсөн шийдвэрлэж чадах цорын ганц Нэгэн мөн. Улмаар, энэ асуудлыг хүн төрөлхтөний өмнөөс шийдэх нь “Ууган нь” болох Түүний үүрэг хариулцлага мөн.



Иймд Ертөнцийн Эзэн Хүүгээ “гэмийн тулд” – өөрөөр хэлбэл, гэмийг үгүй хийхийн тулд илгээжээ (Ром 8:3). Тэгэхдээ Хүүгээ дайсагнасан хүмүүсийн гарт тушаан орхижээ (Ром

8:32). Хүмүүс Есүсийг тамлан зовоогоод зогсохгүй Түүнд ял шийтгэлийн дээд хэмжээг тохоожээ. Түүнийг загалмай дээр цовдлоход Есүс зөвхөн тэдний учруулсан шарх ба үзэн ядалтыг төдийгүй, хорвоо ертөнцийн бүх гэм нүглийг биедээ үүрсэн (1 Петр 2:24; 1 Иохан 2:2).

Нас барахдаа тэр бүх гэм нүглийг булшиндаа авч орон хүчингүй болгосон. Дахин амилахдаа бүгдийг нь тэр булшинд үлдээжээ.



“Ертөнцийн Эзэний Хурга” болох Есүс үхлээрээ үнэхээр “ертөнцийн нүглийг зайлуул”-сан (Иохан 1:29)¹.

Иймд сайн мэдээг товчилж хэлсэн дээрх үгийг илүү ойлгомжтойгоор орчуулахад, “Христ бидний нүглийг авч хаяхын төлөө үхсэн.”

Үүгээр ч барахгүй, Есүс Өөрөө үхэлд “орох” замаар үхлийг дотроос нь ялсан. Үхэгсдээс амилсан нь Есүсийн ялалтыг бүрэн нотолсон. Түүнийг үхэгсдээс амилахад анх удаа Адамын нэгэн үр



удам үхэшгүй амьтай болжээ. Энэ нь шинэ хүн төрөхтөний эхлэлийг тавьсан хэрэг юм. Хуучин хүн төрөлхтөн Христийн араас дагаж шинэчлэгдэх учиртай. Гэтэл юм шинээр эхлэхийн тулд хуучин хэлбэр маяг нь дуусан өнгөрөх ёстой.

Иймд Ертөнцийн Эзэн хүн төрөлхтөнг Христтэй хамт загалмай дээр цовдлогдон үхсэнд тооцдог. Христэд итгэгчдийн тухай Паул тайлбарлахдаа:

1 Жич: Энэ үгийг Иохан тухайн үед Загалмайн явдал болохоос өмнө хэлсэн учраас “зайлуулна” гээд ирээдүйн цагаар ярьсан. Загалмайгаас хойш Ертөнцийн Эзэн бүх гэмийг үгүй болсонд тооцдог учраас “зайлуулсан” гэж энд бичиж болно (2 Коринт 5:19-21). Мэдээж хүний нүдээр харахад энэ дэлхийд мөн бидний амьдралд гэм байдаг хэвээрээ. Гэтэл Ертөнцийн Эзэн бол “байхгүйг байгаагаар дуудагч” бөгөөд Түүний тэгэж дуудсан бүхэн зайлшгүй бий болдог (Ром 4:17). Тийм учраас гэм нүгэл энэ дэлхийгээс бүрэн зайлуулагдах өдөр ирэх нь гарцаагүй.



“...бидний хуучин хүн нь Түүнтэй хамт цовдлогдсоныг бид мэддэг” (Ром 6:6).

Улмаар, “Нэг нь бүх хүмүүсийн төлөө үхсэн тул бүгд үхсэн гэж бид ятгагдсан” гэж Паул хамаг хүн төрөлхтөний тухай ч бичсэн (2 Коринт 5:14). Үүнээс харахад, Христийн загалмай нь Ертөнцийн Эзэний хувьд хуучин хүн төрөлхтөнийг эцэс болгосон (тийм ч учраас Есүсийг мөн “сүүлчийн Адам” гэж нэрлэсэн нь бий – 1 Коринт 15:47). Хүн төрөлхтөнөөр ч барахгүй, “Христ дотор бүтээгдсэн” хамаг хуучин бүтээлд Тэрээр цэг тавьжээ. Газар ба тэнгэр хүртэл ирээдүйд үгүй болж, шинэ тэнгэр, шинэ газар бүтээгдэх болно (Илчлэл 20:11, 21:1). Бүх юм Түүнээс хамааралтай, орчлон дэлхийн хувь заяа Түүнийхтэй нягт холбоотой (Колоссай 1:17).



Шинэ бүтээл бүтээгдэх нь хараахан болоогүй. Христэд итгэдэг, итгэдэггүй хамаагүй бид бүгд өдөр бүр өтөлсөөр, үхэх өдрөө дөхөж явдаг хэвээрээ. Есүс бидний гэмийг Өөр дээрээ авч, загалмай дээр үхсэнээр итгэгч хүмүүс нас бардаггүй болсон гэсэн үг биш. Бид бүгд Адамын хэлбэр маягаар амьдарч, үхэлд захирагддаг хэвээрээ. Адамын араас нас барж, шороонд буцах замаар хувь хүн бүрийн “хуучин хүн” нь бүрмөсөн үгүй болдог.



Гэхдээ бид бүгд мөн Христийн үхэлтэй холбогдсон бөгөөд үүний зорилго бол Түүний амилалтай ч холбогдон, Христийн хэлбэр маягаар амьдрахад оршино. Есүс хүн төрөлхтөнийг төлөөлж үхэлд



орсон учраас хүн төрөлхтөний гишүүн бүрийг үхлээс гарган үхэшгүй амьтай болгох чадвартай. Үхэшгүй шинэ биед маань үхэл нэгэнт оршихгүй учраас гэм нүгэл ч тэр үед байхын аргагүй байх болно.

Бид Түүн шиг зөв шударга байх болно гэсэн үг. “Хэрэв бид Түүний үхэлтэй адил байдалд холбогдсон юм бол, мэдээж Түүний амилалтай нь ч адил байдалд бас холбогдох болно” (Ром 6:5)!

Энэ бүхнийг Паул «Ром» захидлын 5-р бүлэгт бас их тод үгээр тайлбарласан. Үүнд: Адамын “ганц алдаа зөрчлөөс болж бүх хүн ялд унасны адил, [Христийн] ганц зөвт үйл нь бүх хүнийг зөвтгөл ба амь руу дагуулсан юм. Учир нь ганц хүний дуулгаваргүйгээс болж олон хүн нүгэлтэн болгогдсоны адил Ганцын дуулгавраас болж олон хүн зөвт болгогдоно...” (Ром 5:18-19)

Ертөнцийн Эзэнд итгэсэн Есүсийн дуулгавартай байдал Адамын итгэлгүйгээс болж гаргасан алдаа зөрчлийг засч залруулж, хөнөөлт үр дүнг нь гайхалтайгаар тайлж өгсөн.



Дүгнэж хэлэхэд, Христийн загалмай гэм ба үхлийн асуудлыг бүрэн шийдсэн юм. Нүглийг загалмайд хадан, нэгмөсөн зайлуулахын тулд Есүс Өөрөө нүгэл болсон. Үхлийг ялан дийлэхийн тулд Есүс Өөрөө үхсэн.

Адамаас болж бид өөрийн эрхгүй “нүгэлтэн болгогдсон” шиг Христийн ачаар мөн өөрийн мэдэлгүй “зөвт болгогдоно”. Есүсийг бидний адил “нүгэлтэн” биш, харин ч “нүгэл болгосон” тул “Түүний дотор бид Бурханы зөвт байдал болох юм” (2 Коринт 5:21).

Энэ гайхамшиг Есүсийн дуулгавартай байсны ачаар л хийгдэх болно. Бидний бүтээсэн ямар ч гавьяат үйлс үүнд хувь нэмэр оруулж чадахгүй, үйлдсэн гэм нүгэл маань үүнд саад ч болж чадахгүй. Бид Адамын араас дагадаг шигээ цаг нь болохоор Христийн араас дагаж, үхлээс амилах болно.



Түүн шиг амь дүүрэн болохдоо бид Түүн шиг ямар ч гэмгүй, үнэн зөв хүмүүс байх болно. Түүнийг үхэгсдээс амилсны үр дүнд нь бүх хүн төрөлхтөн зогсохгүй, хамаг ертөнц шинээр бүтээгдэх болно (Илчлэл 21:1).

Бичвэрүүдийн ялалтын уухайнд бид одоо ч оролцож болно: “Үхэл ээ, ялалт чинь хаана байна вэ?! Үхэл ээ, хатгуур чинь хаана байна вэ?!”
Үхлийн хатгуур нь нүгэл...”
(1 Коринт 15:55).

Христэд итгэхийн ач холбогдол

“Тийм юм бол өнөөдөр Христэд итгэх ямар хэрэг вэ?” гэсэн асуулт зарим хүнд төрсөн байж магад. Энэ амьдралын хэцүү замаар хөтлөн дагуулж, ханилан хамгаалах Их Эзэнтэй байх юутай их ивээл болохыг ийн асуудаг хүн мэдээгүй биз ээ. Гэм ба үхэл ялагдсан дайсан гэдгийг мэдэх нь ямар тайван сайхан болгодгийг амьдралдаа мэдрээгүй биз ээ.

Итгэгч бид Ертөнцийн Эзэний хувьд өнөөдөр ч Христтэй хамт үхээд зогсохгүй, бас амилсанд тооцогддог (Ром 6:3). Тэр биднийг Христийн Биеийн гишүүн байхаар сонгосон учраас тэр. Тиймээс биднийг өнөөдөр ч сүнсээрээ гэм буруугүй, ариун,



шинэ бүтээл болсон гэж үздэг гэсэн үг. Иймд бид хуучин бүтээлд амьдарч байгаа боловч, хуучин бүтээлд хамрагдахаа больсон. Харин өнөөдөр ч Христийн хаант улсын иргэн гэж тооцогддог. Энэ бол тоохгүй байхын аргагүй дэндүү өндөр аз завшаан ба нэр төр юм!

Ирээдүйд шинэ биетэй болох үед энэ бүхэн бүрэн биелэгдэх нь баттай учраас бид өнөөдөр ч үүнд итгэснээр хайр, амар тайван, баяр хөөр, хүч чадал, цог жавхлан дүүрэн “шинэ амийн дотор явах” боломжтой (Ром 6:4). Бид өнөөдөр ч тэр шинэ загвараар, тэр шинэ хэлбэр маягаар амьдрахад дуудагдсан.



“Хэрэв Христ та нарын дотор байгаа бол, нүглээс болж бие нь үхмэл хэдий ч, зөвт байдлын улмаас сүнс нь амьд байна” (Ром 8:10).

Үхэл оршдог бие махбод маань гэм хийх хандлагатай хэвээрээ ч гэсэн, итгэгч бидний дотор оршдог Ертөнцийн Эзэний Сүнс өөрийн минь сүнсэнд амийн хүчийг нэмж, Христийг дагаж шинэ загвараар амьдрах чадвар хайрладаг гэсэн үг. Түүний үгэнд итгэж дагах нь амьдралын үнэ цэнийг ойлгож, буруутгалгүй амьдарч, сэтгэл амар тайван байж, хуучин бүтээлийн янз бүрийн



шаардлагаас чөлөөлөгдсөн байх зэрэг үлэмж их ивээлийг дагуулна. Улмаар, Түүнд итгэгч бид Түүнийг ирэх өдөр “үхэгсдийн дундаас”, өөрөөр хэлбэл, бусдаас түрүүлээд дахин амилж үхэшгүй амьтай болно (Ром 6:6-13, 1 Коринт 15:22-23).

Гэм ба үхэл Ертөнцийн Эзэнд үйлчлэх учиртай

Учрыг ухан асуудаг хүн Ертөнцийн Эзэний Авралын энэ төлөвлөгөөг тунгаан бодохоор, “хүн төрөлхтөн яагаад заавал гэм ба үхэл үзэх ёстой вэ?” гэж асуухад хүрэх биз ээ. Их Эзэн Адамд өнөө модыг анхааруулсан боловч аюултай жимсийг нь идэхээс хамгаалсангүй. Хүн төрөлхтөнийг нүгэлтэн болохоос болиулсангүй. Яагаад тэр вэ? Хүн юу хийхийг Ертөнцийн Эзэн урьдаас мэдээгүй гэж үү? Эсвэл болиулж амжаагүй гэж үү? Гэм хийхийг нь зогсоох хүч нь хүрээгүй юмуу? Мэдээж үгүй. Ертөнцийн бүх хүчит их Эзэн бүгдийг мэддэг бөгөөд “бүх юмсыг хүсэл хийгээд шийдвэрээрээ үйлддэг” нь хөдөлшгүй үнэн (Эфэс 1:11). Үүнд Ээдэн цэцэрлэгт болсон явдал ч орох нь зайлшгүй. Тэгвэл гэм ба үхэл Ертөнцийн Эзэний зорилгоор бий болсон гэсэн үг. Яагаад тэр вэ?





Номлогчийн үгсийн дагуу “Бардам омгийг нь дарах зорилгоор Ертөнцийн Эзэн хүн төрөлхтөнд ёрын мууг туулж үзэх амьдрал өгсөн” (1:13, Concordant Literal Version-ны дагуухь орчуулга).

Бичвэрээс ажиглавал,

Адам Ева хоёр тэр сайхан цэцэрлэгт байхдаа эдэлж буй жаргалаа ойлгодоггүйн улмаас үнэлдэггүй байсан.

Ээдэн дэх амьдралын бүх ивээлийн төлөө талархах сэтгэл тэдэнд төрөөгүй. Тэдний хувьд амьдрал тийм сайхан л байх ёстой аж.

Харин зовлонг үзсэн хүн жаргал гэж юу болохыг ойлгож үнэлэх нь жам. Юмны учрыг хүнд ойлгуулах, амьдралын хамгийн сайн “багш” бол эсрэгцэл юм. Өөрөөр хэлбэл, юмны мөн чанарыг сурахын тулд хүн заавал эсрэг зүйлийг нь үзэх ёстой.

Гэрэл ямар сайхан байдгийг ойлгохын тулд харанхуйд алхаж үзэх хэрэгтэй. Бие өвдөхөөс нааш хүн эрүүл явахын сайхныг ер нь үнэлдэггүй. Өлсөж үзээгүй хүн өдөр бүр идэх хоолтой байхыг ивээл гэж хардаггүй. Даарч үзээгүй хүн дулаахан



гэртэй байхыг аз жаргал гэж тоодоггүй. Аав ээжийг нас барахаар л хайр халамжийг нь юутай үнэлж баршгүй бэлэг байсныг ухаарах нь даанч олонтаа. Яруу найрагч Чойномын алдартай үг юутай үнэн вэ. Тэрээр шүлэглэхдээ:

“Хатмал цөлд явахад хар ус амттай
Харанхуй шөнийн дунд өнчин зул гэрэлтэй...”

Зовлон үзэх нь ухамсар суухын гол арга зам. Сайн сайхныг ойлгож үнэлэхийн тулд хүн зайлшгүй ёрын мууг үзсэн байх хэрэгтэй. Амиллын

хязгааргүй хүч
чадал дүүрэн
амьдралаар
үнэхээр бахдан
баясахын тулд хүн
доройтон доройтох
амьдралаар явж
үзсэн байх
хэрэгтэй. Амиллын
гэмгүй ариун
байдлын цог
жавхланг
нандигнан хэзээ ч



тавилгүй зууралддаг байхын тулд хүн гэм нүгэлд хутгалдан, буруутгал, ичгүүр ба уй гашуу үзсэн байхаас өөр аргагүй.

Өөрийн өгөх арвин их ивээл ерөөлийг хүн үнэ цэнэтэйд тооцон, үлэмж их баяр хөөр дүүрэн



байгаасай гэж Их Эзэн хүсч, тэр үр дүнд хүрэхээр төлөвлөгөө гаргасан. Гэм ба үхэл тэр төлөвлөгөөнд зайлшгүй шаардлагатай хүчин зүйлс. Гэм ба үхэл нэг ёсондоо Ертөнцийн Эзэнд үйлчлэх зарц гэсэн үг.

Харин төлөвлөгөөний дагуу гэм ба үхэл үүрд мөнхөд оршин тогтнох ёсгүй, нэг л өдөр үйлчлэлээ төгсгөн өнгөрөн одох ёстой. Ертөнцийн Эзэний шинэ бүтээлд “анхны юмс” болох гэм, үхэл ба зовлон оршихгүй нь лавтай (Илчлэл 21:4).



Энэ амьдрал танд заримдаа зовлонтой, хэцүү, шударга бус санагдаж магад. Бид харанхуй энэ хорвоод амьдрахдаа “үхлийн хөндийгөөр” дамжиж

буй хэрэг (Дуулал 23:4). Бид үхэж буй бүтээлд амьдарч байгаа. Энэ амьдрал бол дараагийн амьдралд бэлтгэх бэлтгэл төдий. Та Есүс Христэд итгэвэл тэр хөндийгөөр явсан хэвээрээ, амьдрал янз бүрийн зовлонтой байх нь хэвээрээ.

Гэхдээ үнэнч Ханьтай, бүгдийг мэддэг Зөвлөгчтэй, бүх хүч чадалт Их Эзэнтэй хамт тэр хэцүү замаар явах нь эрс өөр. Улмаар, үхлийн хөндийн уртаар биднийг гарамгай хөтөлсний дараа цаана нь хүлээж буй гайхамшигт ертөнцөд Есүс биднийг аваачихыг бүү март.



Хэцүү үедээ та Христийн тухай сайн мэдээг

өөртөө сануулаарай:

“Христ бидний нүглийн

төлөө үхсэн бөгөөд

оршуулагдан,

Бичвэрийн дагуу гурав

дахь өдөртөө

амилуулагдсан...” (1

Коринт 15:1-4).



Энэ сайхан мэдээ юуны өмнө Христийн тухай ч

гэсэн, бас бидний тухай. Есүс Христ хүн болж

бидний хувь заяаг хуваалцан, бидний гэмийг Өөр

дээрээ авч, бидний үхэх үхэлд хамт орсон учраас

Түүнтэй амь нэгдсэн бид зайлшгүй Түүний араас

дагах болно.

Нас барсан ч гэсэн бид Түүний араас үхлээс

амилж, дуусашгүй яруу сайхан амьдралаар үүрд

мөнхөд баясах болно. Түүнд сэтгэлийн гүнээс

талархан магъя! □

Ихэнх хүмүүс даанч Ертөнцийн Эзэний илчлэлтэд биш,

хүний сэтгэлийг үхэшгүй мөнх гэдэгт итгэдэг. Гэвч

сэтгэлийн үхэшгүйд итгэхэд нь үхлийн чанадад орших

найдлагыг үгүй хийж, улмаар Аврагч Эзэний хайранд

эргэлзэхэд хүргэдгийг та мэдэх үү? Энэ талаар

дараагийн нийтлэлээс уншаарай!



Хэрэглэсэн эх сурвалж

---Ариун Библи (2004; 2013; 2019). Улаанбаатар: Ариун Бичээс Нийгэмлэг.

Энэ судалгаанд АБ гэж товчилсон.

---Concordant Version of the Old Testament (2015). www.concordant.org

---Стандарт Монгол Орчуулгын апп (2023). Энэ судалгаанд СМО гэж товчилсон.

---Strong, J. (1890). Strong's exhaustive concordance of the Bible (with Greek and Hebrew Lexicons). www.blueletterbible.org